



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

21

2013 оны 07 сарын 31 өдөр


Дугаар 269

Улаанбаатар хот

Г Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах
журмыг батлах тухай

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийн явцыг хянах, Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх үндэсний стратеги (2010-2015), Эрүүл мэндийн сайдын 2013 оны "Сүрьеэгийн тархалтын судалгааг зохион байгуулах тухай" 43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдах зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар, техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, техникийн ажлын хэсгийн ажиллах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Сүрьеэгийн тархалтын судалгааны бэлтгэл ажлыг хангаж, судалгааг 2013-2014 онд зохион байгуулж, үр дүнг 2015 оны хоёрдугаар улиралд багтаан тайлагнахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-д даалгасугай.



002258

Эрүүл мэндийн сайдын,
2018 оны 07 сарын 31 өдрийн
269 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

72

“Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

- Удирдах зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Нарийн бичгийн дарга: Сүрьеэгийн тархалтын судалгааны зохицуулагч
- Гишүүд:
ЭМЯ, Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга
ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
ЭМЯ, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга
ЭМЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
ЭМЯ, Бодлого төлөвлөлтийн газрын Анагаах ухааны хөгжил шинэтгэлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
ЭМЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
ЭМЯ, Санхүү эдийн засгийн хэлтсийн салбарын ерөнхий нягтлан
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал ХӨСҮТ, Тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал
ХӨСҮТ, Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга
Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн захирал
ЭМШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал
Үндэсний статистикийн хорооны Хүн ам нийгмийн хэлтсийн дарга (тохиролцсоноор)
Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн зохицуулагч

ДЭМБ-ЫН ХАЛДВАРТ ӨВЧИН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(тохиролцсоноор)

Монголын сүрьеэтэй тэмцэх холбооны
өрөнхийлөгч

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэний
холбооны гүйцэтгэх захирал

Монголын сумын эмч, мэргэжилтэнүүдийн
холбооны тэргүүн

Эрүүл мэндийн сайдын,
2013. оны 07. сарын 31. өдрийн
169 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны удирдах зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 “Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны удирдах зөвлөл (цаашид “удирдах зөвлөл” гэх) нь судалгааг явуулах ажлыг нэгдмэл удирдлагаар хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх судалгаанд холбоотой бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч байгууллагуудын ажлын уялдааг ханган хяналт, үнэлгээг нэгтгэн зохицуулах чиг үүрэгтэй ажиллана.
- 1.2 Удирдах зөвлөл нь ажлын үр дүнгээ захиалагч байгууллагад тайлagnana.
- 1.3 Удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зардлыг Засгийн газар хариуцна.

Хоёр. Удирдах зөвлөлөөс явуулах үйл ажиллагаа

- 2.1 Судалгааг бодлого, стратеги, хяналт, үнэлгээний нэгдсэн удирдлагаар хангах
- 2.2 Хэрэгжилтийн явцад хяналт тавих ба судалгааны үзүүлэлт, аргачлал, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэх, зөвлөх

Гурав. Удирдах зөвлөлийн хуралдаан

- 3.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсоноор удирдах зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болно.
- 3.2 Удирдах зөвлөл сард нэг удаа хуралдана
- 3.3 Асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ
- 3.4 Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 7 хоногийн өмнө гишүүдэд тараана
- 3.5 Дараагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг өмнөх хуралдаан дээр урьдчилан тохиролцож болно
- 3.6 Зөвлөлийн хуралдаанаас цаашдаа үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн асуудлаар яамд бусад байгууллагаас саналыг бичгээр авч зөвлөмжид тусгаж байна.
- 3.7 Удирдах зөвлөлийн даргын эзгүйд зөвлөл хуралдахгүй. Зайлшгүй хуралдах шаардлага гарвал Зөвлөлийн даргын саналыг урьдчилан авсны үндсэн дээр зөвхөн түүний томилсон гишүүний удирдлагаар хуралдаж болно.

Дөрөв. Удирдах зөвлөлийн даргын бүрэн эрх


- 4.1 Зөвлөлийн ажлыг удирдан зохион байгуулах
- 4.2 Хуралдааны бэлтгэлийг шалгаж ханггуулах, хурлыг даргалах
- 4.3 Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, төлөөлөх
- 4.4 Гишүүдэд ажлын хэлс олгох асуудлыг шийдвэрлэх
- 4.5 Удирдах зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 4.6 Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэдээлэл, бусад материалыг ажлын хэсгийн ажилтан нараар гаргуулан авах
- 4.7 Удирдах зөвлөлийн гишүүдийн хариуцах ажлын чиглэл, хуваарийг батлах, дүгнэх

Тав. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын бүрэн эрх

- 5.1 Зөвлөлийн ажлыг удирдан зохион байгуулахад Зөвлөлийн даргад дэмжлэг үзүүлэх
- 5.2 Хуралдааны бэлтгэлийг хангах
- 5.3 Хуралдааны тэмдэглэл, бусад бичиг баримтыг бүрдүүлэх, баримтжуулан хадгалах ажлыг зохион байгуулах
- 5.4 Удирдах зөвлөлийн нарийн бичгийн ажлын үүргийг тухайн судалгаа хийж байгаа байгууллага хариуцна.

Зургаа. Удирдах зөвлөлийн гишүүний эрх үүрэг

- 6.1 Удирдах зөвлөлийн гишүүн тодорхой асуудлыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх санал оруулах эрхтэй бөгөөд ингэхдээ зөвлөлийн даргатай урьдчилан тохиролцсон байна. Хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг санал оруулж байгаа гишүүн хариуцан хангуулна.
- 6.2 Удирдах зөвлөлийн гишүүн нь шаардагдах мэдээлэл, бусад материалыаар хангагдах эрхтэй.
- 6.3 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар гишүүн санал гаргах бүрэн эрхтэй бөгөөд гаргасан саналыг тухайн байгууллагыг төлөөлж буй санал гэж үзэх учраас уг асуудлаар өөрийн яам, байгууллагынхаа удирдлагатай урьдчилан сайтар тохиролцсон байна.
- 6.4 Удирдах зөвлөлийн уулзалтаар хэлэлцсэн асуудал, зөвлөмжийг гишүүд өөрийн харьяа яам байгууллагад эргэн танилцуулж байх үүрэг хүлээнэ.
- 6.5 Удирдах зөвлөлийн уулзалтанд оролцох боломжгүй болсон тохиолдолд удирдах зөвлөлийн даргад мэдэгдэж чөлөө авах ба хэлэлцэх асуудлын талаархи саналаа бичгээр ирүүлнэ.



“Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Техникийн ажлын хэсгийн ахлагч: ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

Нарийн бичгийн дарга: ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга

Гишүүд : ЭМЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн эрүүл мэндийн газрын Халдварт өвчний тандалт зохицуулалтын албаны дарга

Нийслэлийн эрүүл мэндийн газрын Өрхийн эрүүл мэндийн төвийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ХӨСҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн Тандалт Судалгааны Албаны лабораторийн тасгийн эрхлэгч

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч

ХӨСҮТ-ийн Онош Зүйн тасгийн эрхлэгч

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тархвар судлаач

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албаны хяналтын их эмч

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албаны лабораторийн тасгийн их эмч

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албаны зөвлөх эмч

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникийн их эмч

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн сүрьеэз хариуцсан мэргэжилтэн

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн (тохиролцсоноор)

Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн гүйцэтгэх захирал

“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын мэргэжилтэн

ЭМШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш

ЭМШУИС-ийн Анагаахын сургуулийн багш

Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтэний холбооны гүйцэтгэх захирал

Сүрьеэгийн тархалтын судалгааны зохицуулагч

Сүрьеэгийн тархалтын судалгааны туслах мэргэжилтэн

Эрүүл мэндийн сайдын,
2019.07.31
169 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

“Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны Техникийн ажлын хэсгийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Сүрьеэгийн тархалтын судалгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, уялдуулан зохицуулах Техникийн ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь сар тутам зохион байгуулагдах ээлжит хуралдаан байна.
- 1.2. Ээлжит бус хуралдааныг Техникийн ажлын хэсгийн дарга зарлан хуралдуулна.
- 1.3. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг өргөтгөсөн байдлаар хийж болно. Энэхүү хуралд оролцогчдын бүрэлдэхүүнийг ажлын хэсгийн дарга тогтооно.
- 1.4. Хурлаар хэлэлцэх асуудлыг 5 хоногийн өмнө ажлын хэсгийн гишүүдэд тараасан байна.
- 1.5. Сүрьеэгийн тархалтын судалгааг зохион байгуулах техникийн ажлын хэсгийн хуралдаан нь судалгааны бэлтгэл ажил болон талбарын ажлын явц, байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, ажлын үр дүн, үр нөлөөг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар санал солилцож, хийх ажлыг төлөвлөн тодорхойлоход чиглэгдэнэ.
- 1.6. Ажлын хэсгийн дарга бөгөөд ХӨСҮТ-ийн халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхлэсэн дэд захирал хурлыг даргалан явуулна. Ажлын хэсгийн даргын эзгүйд Нарийн бичгийн дарга хурлыг даргалан хийнэ.

Хоёр: Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх асуудал

- 2.1. Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах
- 2.2. Судалгааны явцад тулгамдсан асуудлыг Удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэх
- 2.3. Судалгааны протокол боловсруулахад зөвлөгөө өгөх, биечлэн оролцох
- 2.4. Стандарт үйл ажиллагааны удирдамж боловсруулахад зөвлөгөө өгөх, хамтарч ажиллах
- 2.5. Судалгаанд шаардлагатай тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих
- 2.6. Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл боловсруулах, талбарын урьдчилан судалгаа, сургалт хийхэд мэргэжил арга зүйн туслалцаагаар хангах
- 2.7. Судалгааны багийн тайланг кластер бүрийн дараа хэлэлцэж, үнэлэх
- 2.8. Судалгааны багийн сар бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх
- 2.9. ДЭМБ болон олон улсын зөвлөх мэргэжилтэнүүдтэй хамтарч ажиллах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцох
- 2.10. Сүрьеэгийн тархалтын судалгааг зохион байгуулах, уялдуулан зохицуулахтай холбоотой аймаг, дүүргийн удирдлагуудтай уулзах, санал солилцох, дэмжлэг авах
- 2.11. Талбарт мэдээлэл цуглуулах ажлын явцад хөндлөнгийн хяналт хийж, үнэлгээ дүгнэлт гаргах

2.12. Бусад тулгамдсан асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх
Гурав. Хуралдааны бэлтгэл хангах

- 3.1. Хурлыг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны Сүрьеэгийн тархалтын судалгааны нэгжээс зохион байгуулна.
- 3.2. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг ажлын хэсгийн дарга батална.
- 3.3. Хурлаар хэлэлцүүлэх материалыг хурал хийхээс 5 хоногийн өмнө ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн байна.
- 3.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан ажлын хэсгийн даргаар хянуулж батлуулна.
- 3.5. Ажлын хэсэг нь Эрүүл мэндийн яамны дэргэдэх сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөлтэй нягт хамтарч ажиллана.
- 3.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хэлэлцүүлэхээр ирүүлсэн материалыг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 3.7. Хурлын шийдвэрийн төслийг тухайн асуудал оруулж байгаа мэргэжилтэнүүд боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудын саналыг авсан байна.
- 3.8. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын батлагдсан төлөвлөгөө, хуралд хэлэлцүүлэх материалын ажлын хэсгийн дарга, гишүүдэд батлагдсан даруйд бичгээр болон И-мэйл хаягаар хүргүүлнэ.
- 3.9. Хурлын байрны нөхцөл, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах ажлыг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба хариуцна.
- 3.10. Хурлыг өргөтгөн зохион байгуулж байгаа үед гаднаас орох хүмүүсийн нэrsийн жагсаалтыг нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн даргад танилцуулж батлуулна.

Дөрөв. Хуралдаан зохион байгуулах, шийдвэр гаргах

- 4.1. Ажлын хэсгийн дарга хурлыг нээж, тухайн өдрийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг танилцуулж, төлөвлөгөөнд орсон дарааллын дагуу хэлэлцүүлнэ.
- 4.2. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга өмнөх хурлаас гаргасан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцад хяналт тавьж энэ талаарх мэдээллийг бэлтгэн хийнэ.
- 4.3. Судалгаатай холбоотой хэлэлцэж байгаа асуудалд холбогдох зураг, видео бичлэг, биет зүйлс, түүний загвар, хэсгийг хурал дээр үзүүлж болно.
- 4.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлын явцын талаарх тэмдэглэлийг бичнэ.
- 4.5. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн даргад хянуулан гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 4.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад шуурхай хүргэнэ.

Тав. Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих

- 5.1. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга буюу ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга нь сүрьеэгийн тархалтын судалгааны техникийн ажлын хэсгийн хурлын явц, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт хийж хагас, бүтэн жилээр Удирдах зөвлөлийн хуралд танилцуулна.